



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/21/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/21/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Ахлах аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт	12
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ҮСХ	Үндэсний Статистикийн хороо
СХ	Статистикийн хэлтэс
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,968,821.00	2,847,571.00
2	БАРАА МАТЕРИАЛ	2,968,821.00	2,847,571.00
3	Хангамжийн материал	2,968,821.00	2,847,571.00
4	Бичиг хэргийн материал	465,750.00	234,500.00
5	Аж ахуйн материал	2,503,071.00	2,613,071.00
6	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	67,524,752.07	67,655,831.62
7	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	67,524,752.07	67,655,831.62
8	Биет хөрөнгө	67,524,752.07	67,655,831.62
9	Авто-тээврийн хэрэгсэл	42,900,000.00	42,900,000.00
10	Хуримтлагдсан элэгдэл	-3,574,999.98	-10,724,999.94
11	Машин тоног төхөөрөмж(компьютер)	57,997,343.10	70,356,943.10
12	Хуримтлагдсан элэгдэл	-31,595,695.31	-38,476,111.50
13	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,509,915.00	12,809,915.00
14	Хуримтлагдсан элэгдэл	-8,711,810.74	-9,209,915.04
15	Програм хангамж	450,000.00	450,000.00
16	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
17	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	70,493,573.07	70,503,402.62
18	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	70,493,573.07	70,503,402.62
19	Засгийн газрын хувь оролцоо	70,493,573.07	70,503,402.62
20	Хуримтлагдсан үр дүн	70,493,573.07	70,503,402.62
21	Өмнөх үеийн үр дүн	10,874,281.89	70,493,573.07
22	Тайлант үеийн үр дүн	59,619,291.18	9,829.55
23	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	70,493,573.07	70,503,402.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	441,794,072.00	239,245,310.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,983,981.00	7,685,600.00
3	Нийтлэг татварын бус орлого	64,983,981.00	7,685,600.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,983,981.00	0
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,983,981.00	0
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	7,575,600.00
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	110,000.00
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,810,091.00	231,559,710.00
9	Улсын төвлөрсөн төсвөөс	97,157,000.00	99,725,000.00
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,157,000.00	99,725,000.00
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	279,653,091.00	131,834,710.00
12	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,831,000.00	23,902,000.00
13	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	273,822,091.00	107,897,710.00
14	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	35,000.00
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	382,174,780.82	239,235,480.45
16	УРСГАЛ ЗАРДАЛ	382,174,780.82	239,235,480.45
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,086,582.48	234,550,544.11
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,740,587.00	84,410,966.66
19	Үндсэн цалин	53,280,990.00	59,078,640.00
20	Нэмэгдэл	14,915,551.00	17,303,341.86
21	Унаа хоолны хөнгөлөлт	3,888,400.00	4,091,999.80
22	Урамшуулал	5,655,646.00	3,936,985.00
23	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,717,571.66	10,951,731.00
24	Тэтгэврийн даатгал	6,607,949.87	7,577,143.68
25	Тэтгэмжийн даатгал	777,404.86	842,221.83
26	ҮОМШӨ-ний даатгал	621,924.89	675,357.52
27	Ажилгүйдлийн даатгал	155,480.97	169,464.31
28	Эрүүл мэндийн даатгал	1,554,811.07	1,687,543.66
29	Хангамж, бараа материалын зардал	4,968,095.00	2,229,750.00
30	Бичиг хэрэг	3,059,320.00	463,850.00
31	Тээвэр, шатахуун	845,000.00	681,112.00
32	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,745.00	667,188.00
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	368,030.00	417,600.00
34	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	264,560,709.00	120,999,376.00
35	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	263,612,009.00	119,985,376.00
36	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00
37	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	829,900.00	895,200.00
38	Бараа үйлчилгээний бусад зардал	10,099,619.82	15,958,720.45
39	Бараа үйлчилгээний бусад зардал	0	1,000,000.00
40	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	244,700.00	430,200.00
41	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	9,854,919.82	14,528,520.45
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,088,198.34	4,684,936.34
43	Бусад урсгал шилжүүлэг	316,800.00	253,400.00
44	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	316,800.00	253,400.00
45	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,771,398.34	4,431,536.34
46	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,169,266.34	445,402.34
47	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,602,132.00	3,986,134.00
48	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	59,619,291.18	9,829.55
49	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	59,619,291.18	9,829.55

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	10,874,281.89	10,874,281.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	10,874,281.89	10,874,281.89
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	59,619,291.18	59,619,291.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	70,493,573.07	70,493,573.07
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	70,493,573.07	70,493,573.07
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	70,493,573.07	70,493,573.07
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	9,829.55	9,829.55
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	70,503,402.62	70,503,402.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	376,810,091.00	231,559,710.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	376,810,091.00	231,559,710.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	97,157,000.00	99,725,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97,157,000.00	99,725,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	279,653,091.00	131,834,710.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,831,000.00	23,902,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	273,822,091.00	107,897,710.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	35,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	372,810,091.00	224,475,710.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	372,810,091.00	224,475,710.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,721,892.66	219,790,773.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	77,740,587.00	84,410,966.66
210101	Үндсэн цалин	53,280,990.00	59,078,640.00
210102	Нэмэгдэл	14,915,551.00	17,303,341.86
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,888,400.00	4,091,999.80
210104	Урамшуулал	5,655,646.00	3,936,985.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,717,571.66	10,951,731.00
210201	Тэтгэврийн даатгал	6,607,949.87	7,577,143.68
210202	Тэтгэмжийн даатгал	777,404.86	842,221.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	621,924.89	675,357.52
210204	Ажилгүйдлийн даатгал	155,480.97	169,464.31
210205	Эрүүл мэндийн даатгал	1,554,811.07	1,687,543.66
2104	Хангамж, бараа материалын зардал	2,545,175.00	2,226,100.00
210401	Бичиг хэрэг	541,400.00	460,200.00
210402	Тээвэр, шатахуун	845,000.00	681,112.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	695,745.00	667,188.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	463,030.00	417,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,384,959.00	117,798,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	266,326,959.00	116,865,376.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	939,200.00	814,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,600.00	4,403,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	333,600.00	3,403,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,088,198.34	4,684,936.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	316,800.00	253,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	316,800.00	253,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,771,398.34	4,431,536.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,169,266.34	445,402.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,602,132.00	3,986,134.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,000,000.00	7,084,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,000,000.00	7,084,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,000,000.00	7,084,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,000,000.00	7,084,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,000,000.00	7,084,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,000,000.00	-7,084,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	99,725,000.00	99,279,597.66	445,402.34	99.6%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	99,725,000.00	99,279,597.66	445,402.34	99.6%
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,471,600.00	99,026,197.66	445,402.34	99.6%
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	84,412,500.00	84,410,966.66	1,533.34	100.0%
5	Үндсэн цалин	59,218,600.00	59,078,640.00	139,960.00	99.8%
6	Нэмэгдэл	16,127,500.00	17,303,341.86	-1,175,841.86	107.3%
7	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	4,091,999.80	487,200.20	89.4%
8	Урамшуулал	4,487,200.00	3,936,985.00	550,215.00	87.7%
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,395,600.00	10,951,731.00	443,869.00	96.1%
10	Тэтгэврийн даатгал	8,019,200.00	7,577,143.68	442,056.32	94.5%
11	Тэтгэмжийн даатгал	844,100.00	842,221.83	1,878.17	99.8%
12	ҮОМШӨ-ний даатгал	675,300.00	675,357.52	-57.52	100.0%
13	Ажилгүйдлийн даатгал	168,800.00	169,464.31	-664.31	100.4%
14	Эрүүл мэндийн даатгал	1,688,200.00	1,687,543.66	656.34	100.0%
15	Хангамж, бараа материалын зардал	2,226,100.00	2,226,100.00	0.00	100.0%
16	Бичиг хэрэг	460,200.00	460,200.00	0.00	100.0%
17	Тээвэр, шатахуун	718,300.00	681,112.00	37,188.00	94.8%
18	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630,000.00	667,188.00	-37,188.00	105.9%
19	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	417,600.00	417,600.00		100.0%
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,153,700.00	1,153,700.00		100.0%
21	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	220,800.00	220,800.00		100.0%
22	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00		100.0%
23	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	814,100.00	814,100.00		100.0%
24	Бараа үйлчилгээний бусад зардал	283,700.00	283,700.00		100.0%
25	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	283,700.00	283,700.00		100.0%
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	253,400.00	253,400.00		100.0%
27	Бусад урсгал шилжүүлэг	253,400.00	253,400.00		100.0%
28	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	253,400.00	253,400.00		100.0%
29	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	99,725,000.00	99,279,597.66	445,402.34	99.6%
30	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	99,725,000.00	99,279,597.66	445,402.34	99.6%
31	Улсын төсвөөс санхүүжих	99,725,000.00	99,279,597.66	445,402.34	99.6%
32	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	13.00	13		100.0%
33	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1		100.0%
34	Төсвийн байгууллага	1.00	1		100.0%
35	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.00	6		85.7%
36	Удирдах ажилтан	1.00	1		100.0%
37	Гүйцэтгэх ажилтан	4.00	4		100.0%
38	Гэрээт ажилтан	1	1		100.0%
39	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6		100.0%
40	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	5	5		100.0%
41	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1	1		100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон

/төгрөг/

Код	Үзүүлэлт	гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,764.576
2	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	120,764.576
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	120,764.576
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	116,644.576
5	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	116,644.576
6	Бараа үйлчилгээний бусад зардал	4,120.000
7	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000.000
8	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,120.000
9	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,084.000
10	Дотоод эх үүсвэрээр	7,084.000
11	Тоног төхөөрөмж	7,084.000
12	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	127,848.576
13	Нэмэлт санхүүжилтийн орлого	127,848.576
14	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,902.000
15	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,911.576
16	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Статистикийн тухай хуулийн 11.1-т “Статистикийн байгууллага нь улс, бүс нутаг, аймаг, нийслэлийн эдийн засаг, хүн ам, нийгэм, байгаль орчны талаарх статистикийн мэдээллээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад адил тэгш төрийн үйлчилгээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Үндэсний Статистикийн хорооны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *Статистикийн тухай Монгол улсын хуулийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оршино*” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрддөг хууль, журамд өөрчлөлт дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй” гэснээр даатгуулагч болон ажил олгогчоос төлөх НДШ тус бүр 1%-аар буурч өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус хэлтсийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд ҮСХ-оос цахим хяналт шалгалт хийгдсэн байна. Мөн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах зөвлөмж хүргүүлж Статистикийн хэлтсийн даргын 2021 оны 02 сарын 15-ны а/03 тоот тушаалаар 2021 оны 1-р улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 220.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 1.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.1 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан бөгөөд материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	2.9	2.8	-0.1	-3.4
Үндсэн хөрөнгө	67.5	67.7	0.2	0.3
Нийт хөрөнгө	70.4	70.5	0.1	0.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	70.4	70.5	0.1	0.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	70.4	70.5	0.1	0.1

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 3.4 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 2.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 30.5 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 0.1 сая төгрөг нийт 33.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 30.7 сая төгрөгийн зарцуулалт гарч, 2.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 0.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 67.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 7.1 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 7.6 сая нийт 14.7 сая

төгрөгөөр нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал 14.5 сая төгрөгөөр буурч 67.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 70.5 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97.2	99.7	2.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	279.7	131.8	(147.9)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	65.0	7.6	(57.4)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	0.1	0.1
Үйл ажиллагааны орлого	441.8	239.2	(202.6)
Цалин, шимтгэлийн зардал	87.5	95.4	7.9
Бусад бараа үйлчилгээний зардал	5.0	2.2	(2.8)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	264.6	120.9	(143.7)
Бараа үйлчилгээний бусад зардал	8.3	16.0	7.7
Урсгал шилжүүлэг	15.1	4.7	(10.4)
Үйл ажиллагааны зардал	380.34	239.1	(141.2)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	61.44	0.09	(61.3)

Статистикийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 2.6 сая төгрөгөөр санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 105.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 5.6 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 99.4 сая төгрөгөөр хянасан бөгөөд 2021 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн төсвийн тодотголоор 0.3 сая төгрөгөөр дахин нэмэгдүүлж 99.7 сая төгрөг болгож батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд улсын төсвөөс 99.7 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 131.8 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 23.9 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 107.9 сая төгрөг нийт 231.6 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 227.2 сая төгрөг зарцуулж 4.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Энэ нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 4.0 сая төгрөг, бараа үйлчилгээний урсгал зардлуудын хэмнэлт 4.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар ҮСХорооноос судалгааны зардалд 107.9 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс аж ахуйн нэгжийн, мал тооллогын зардал 23.9 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

2021 онд 5 жилд нэг удаа болдог аж ахуйн нэгжийн улсын нэгдсэн тооллого хийгдэж 1935 аж ахуйн нэгж хамрагдсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 6 үндсэн зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98.7 хувь байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 3 арга хэмжээнд зориулан нийт 231.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 227.5 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвийн гүйцэтгэл 99.6 хувь байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:

Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.

2.Суудлын автомашин ашиглалтын хувьд: Лада 4*4 маркийн 2019 онд үйлдвэрлэгдсэн 42.0 сая төгрөг, шатахууны зардалд 2.7 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочгүй,

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байдаг.

Энэ санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад 2021 онд 149 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад зөрчилтэй асуудал илрээгүй байна.

Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар авч үзэхэд 4.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж аудитаар Сангийн Сайдын 2017 оны 390 тушаал, Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 347 тушаалыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлж биелэлтийн хангуулсан. Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй болно. Иймд Зөрчилгүй дүгнэлт өглөө.

